

# "МАЛЧДЫН ХҮҮХДҮҮДЭД ҮЗҮҮЛЭХ ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ" төсөл

## Хэрэгжих хугацаа:

2016.04.01-2016.06.30

## Үйл ажиллагаа:

- Малчдын хүүхдүүдэд дулаан хувцас, хөнжил ба ариун цэвэр эрүүл ахуйн хэрэгсэл өгөх, сургууль болон дотуур байрын халаалтын зардлыг шийдэх
- Малчдын хүүхдүүдэд сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, боловсролын тасралтгүй үйлчилгээг авахад нь туслах

## Төсөл хэрэгжих аймгууд:

Архангай, Өвөрхангай



# СЭТГЭЛИЙН ЗОВУУРЬТАЙ ХҮҮХДЭД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

## Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо Арizona төв, 4-р давхар

Шуудангийн хаяг: Төв шуудан, ШХ-1023 Улаанбаатар 13, Монгол улс

Утас: +976-11-329365; 329371

Факс: +976-11-329361

Э-шуудан: [secretary@savethechildren.mn](mailto:secretary@savethechildren.mn)

Вэб хуудас: [www.savethechildren.mn](http://www.savethechildren.mn)

Save the Children in Mongolia

Save the Children MN

Багш нарт зориулав

# СЭТГЭЛИЙН ЗОВУУРЬТАЙ ХҮҮХДЭД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Багш Таны ангийн сурагчдаас хэн нэгний анхаарал суларч, хичээлдээ муудаад байна уу? Магадгүй түүний сэтгэл ямар нэг зүйлд зовж байж болох юм.

Сэтгэлийн зовуурьтай хүүхэд янз бүрийн зан авир гаргадаг. Хүүхэд дараах зан авир гаргаж буй эсэхийг багш Та ажиглаарай.

7-12 насны хүүхдийн гаргах нийтлэг зан авир	Өсвөр насны хүүхдийн гаргах нийтлэг зан авир
<ul style="list-style-type: none"> <li>• Дуугаа хураах, зожигрох, бусдаас хөндийрөх</li> <li>• Будилах, эргэлзэн тээнэгэлзэх</li> <li>• Сэтгэл зовоосон зүйлийн талаар дахин дахин ярих</li> <li>• Хичээлдээ явахаас дургүйцэх</li> <li>• Айж түгших, сандрах, түүнийгээ илэрхийлэх</li> <li>• Ой санамж, анхаарал төвлөрүүлэх чадвар муудах</li> <li>• Унтах, идэх зуршил өөрчлөгдөх</li> <li>• Уурлаж бухимдах, тайван бус байх, түрэмгий догшин авирлах</li> <li>• Хөдөлгөөн өөрчлөгдөх</li> <li>• Стрессээс үүдэж бие нь өвдөх (толгой, гэдэс өвдөх гэх мэт)</li> <li>• Өөрийгөө хараан зүхэх, буруутгах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гутарч шаналах</li> <li>• Бодолд дарагдах, өөрийгөө өрөвдөх</li> <li>• Харилцааны хэв маяг нь өөрчлөгдөх</li> <li>• Эрсдэлтэй зүйл хийх</li> <li>• Буруу нөлөөнд автах</li> <li>• Алив зүйлтэй нүүр тулахаас зайлсхийж зугатах, догшин ширүүн авирлах</li> <li>• Ертөнцийг үзэх үзэл бараг бүхлээрээ өөрчлөгдөх</li> <li>• Одоо болон ирээдүйдээ итгэл алдрах</li> <li>• Эцэг эх, томчуудын үгийг үл дагах</li> <li>• Эцэг эх, асран хамгаалагчаасаа илүү үе тэнгийнхэндээ хэт найдах</li> </ul>

Эдгээр зан авир сурагчдад илэрвэл багш Та тэдэнд туслаарай.

## Хүүхэдтэй ганцаарчлан, чин сэтгэлээсээ ярилцана. Ингэхдээ багш Та дараах зүйлийг анхаараарай:

- Хүүхдийн яриаг таслалгүй, шүүж цэгнэлгүй сонсоорой.
- Дараа нь, хүнд хэцүү зүйл тохиолдоход дээрх зан авир гаргах нь хэвийн зүйл болохыг хүүхдэд тайлбарлаж ойлгуулна. Ингэснээр хүүхэд яагаад уурлаж бухимдаад байгаа, яагаад унтаж, идэж чадахгүй байгаа, яагаад хийх дуртай зүйлээ хийх сонирхолгүй болсноо ойлгоно. Энэ нь хүүхдэд “би өөрчлөгдөөгүй, түр зуур ингэж байна” гэдгээ мэдэхэд нь тусална.
- Ямар нэг хүнд, хэцүү зүйл тохиолдоход бүх хүүхэд дээр дурьдсан зан авир гаргадаг гэдгийг хүүхдэд тайлбарлана. Ингэснээр бусад хүүхэд ч гэсэн түүнтэй адил зан авир гаргадаг гэдгийг мэднэ. Энэ нь хорвоогийн хүмүүсээс ганцаараа зовж буй мэт мэдрэмжийг багасгаж, хүүхдэд итгэл найдвар төрүүлж, хурдан тайвшрахад нөлөөлдөг.
- Ихэнх хүүхэд сэтгэлийг нь зовоосон зүйлээ даван туулж чаддаг гэдгийг хүүхдэд тайлбарлаж ярина.
- Зурах, дуулах, бүжиглэх, хөгжим сонсох гэх мэт сонирхдог зүйлээ хийхийг хүүхдэд зөвлөнө.
- Хичээлдээ анхаарах нь түүний ирээдүйд чухал гэдгийг хүүхдэд тайлбарлана.

Мал төллөх үеэр хүүхдүүд гэртээ очиж эцэг эхдээ туслах нь их. Энэ нь хүүхдийг хичээл сургуулиас нь хөндийрүүлэх, сэтгэлд нь зовнил үүсгэх сөрөг нөлөөтэйг анхаарна уу. Иймд малчдын хүүхдүүдийн эрхийг хангахын тулд нийгэм-сэтгэлзүйн болон боловсролын дэмжлэг үзүүлэх нь чухал юм.

Та сэтгэл нь зовуурилсан сурагчтайгаа дээрх байдлаар ганцаарчлан ярилцаж, түүний сэтгэл санааг тайвшруулснаар сурагч тань тун удахгүй хичээлдээ урьдын адил анхаарч, сайн суралцах болно.

**Хүүхдэд туслахдаа сургуулийнхаа нийгмийн ажилтнаас зөвлөгөө аваарай.**